

**“Стандарт ноос” ХК-ийн 2026 оны хувьцаа эзэмшигчдийн
хурлын тэмдэглэл**

2026 оны 3-р сарын 24-ний өдөр.

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2025 оны 3 дүгээр сар 24-ний өдөр “Улаанбаатар хивс” ХК-ийн хурлын танхимд 11.10 цагаас эхлэв.

Хурлын ирцийг компанийн ТУЗ-ийн 2026.02.06-ны өдрийн 02\ 2026 тоот тогтоолоор томилогдсон тооллогын комиссын дарга Б.Соёлмаа ирц бүртгэлийн дүнгийн тухай тооллогын комиссын тогтоол 01-ийг танилцуулав. Үүнд хуралд оролцсон хувьцаа эзэмшигч 4, ирц 209487 ширхэг хувьцаа буюу 68,63% болж, Компанийн тухай хуулийн 63.5., 69.1 болон Компанийн дүрмийн дагуу хурлын ирц хангалттай, хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болохыг мэдэгдэв. Хуралд хувьцаа эзэмшигч Л.Цэндээхүү, З.Эрдэнээ, УБ хивс ХК-ийн орлогч захирал З.Мөнхмаа, Б.Ганболд болон ТУЗ-ийн гишүүн Ц.Зоригт, Ё.Энхтөр, Батболд, Цэвээнравдан нар оролцов. ТУЗ-ийн нбд Л.Цэвээнравдан компанийн ТУЗ-ийн 2026.02.06-ны өдрийн 02 тоот тогтоолоор ХЭХ-ын даргаар ТУЗ-ийн гишүүн Ё.Энхтөр томилогдсон болохыг танилцуулж, хурал удирдахыг хүсэв.

Ё.Энхтөр : Хурал зохион байгуулагчаас та бүхэнд тараасан хурлын материалын дагуу хэлэлцэх асуудал, хурлын дотоод журмаа танилцуулья. Хурлын хэлэлцэх асуудал :

- “Стандарт ноос” ХК-ийн 2025 оны ерөнхий байдал, 2026 оны үндсэн зорилтын тухай.
- “Стандарт ноос” ХК-ийн санхүүгийн тайлан, аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт
- ТУЗ-ийн гишүүдийн сонгууль гэсэн 3 асуудал хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлаа батлах уу.

Хувьцаа эзэмшигч нар бүгд зөвшөөрөв.

Ё.Энхтөр : Дотоод журмыг хурлын материалд төлөвлөж оруулсан, хурлыг 11.00-13.00 цагийн хооронд багтааж хийхээр төлөвлөсөн, түүний дагуу дотоод журмаа батлах уу.

Хувьцаа эзэмшигч нар бүгд зөвшөөрөв.

Ё.Энхтөр : Хэлцэх асуудлын дагуу 1-р асуудалдаа шууд орьё, Стандарт ноос ХК-ийн ТУЗ-ийн дарга Ц.Зоригт танилцуулна, Хурлыг шуурхайлж эхлээд хэлэлцэх асуудлуудаа сонсоод дараа нь санал, шүүмжлэлдээ орно, хүн бүр дээр 5 минут гэж тогтох уу.

Бүгд зөвшөөрөв.

Ц.Зоригт : Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдөр буюу 3-р сарын 02-ны өдрийн байдлаар хот, хөдөөгийн үнэт цаасны 38 брокер-дилерийн компанийн харилцагч болох 559 хүн тус компанийн хувьцааг эзэмшиж байгаа бөгөөд компанийн зах зээлийн үнэлгээ нь 140,4 сая төгрөг болж өнгөрсөн оноос 38 хувиар буурсан. Стандарт ноос ХК-ийн ноос угаах үйлдвэр нь 2024 оны 8-р сард ашиглалтанд орсон бөгөөд 2025 онд үйл ажиллагааны зардалд нийтдээ 125,6 сая ₮-ийн зардал гаргаж аудитаар хянагдсан байна

Үйлдвэрийн хувьд одоо хүртэл үйлдвэрлэл, санхүүгийн хувьд бүрэн бие даасан үйл ажиллагаа явуулж чадахгүй байгаа тул төсөл хэрэгжүүлэгч байгууллагын санхүүжилтэнд тулгуурласан хэвээр байгаа ба өр төлбөрийн хэмжээ нийтдээ 1642,1 сая төгрөг болсон. Компани нь 2025 оны үйл ажиллагааны үр дүнгээс ногдол ашиг хуваарилах эсэх тухай асуудлыг хуулийн хугацаанд нь хэлэлцэж, үйлдвэрлэл, үйл ажиллагаа, санхүүгийн боломжийн хувьд ногдол ашиг хуваарилах боломжгүй тухай тогтоолыг гаргаж, СЗХ, МХБ болон хувьцаа эзэмшигч нартаа мэдэгдсэн.

2026 оны хувьд ноос угаах үндсэн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд шинэчлэл хийж, ноос угаах хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлж, 14 цагт 12 тн. ноос угаах хүчин чадалтай, 1,5 м. ажлын өргөнтөй, 10 ширхэг хатаагч барабантай, MDYS-200 маркийн өндөр бүтээмжтэй пресстэй ноос угаах шугамыг шинээр суурилуулан гадаад дотоодын хэрэглэгч нарт угаасан ноосоо нийлүүлэх томоохон зорилт тавин ажиллаж байна. Хэрвээ бид энэ жилдээ үйлвэрийн хүчин чадлаа нэмэгдүүлэн үйл ажиллагаагаа зөв зохион байгуулан ажиллаж чадвал хөрөнгө оруулалтын зээлээ 3 жилд багтаан төлөх боломжтой болох тухай холбогдох тооцоо судалгаа, төлөвлөгөө гарган ажиллаж байна. Үйлдвэрийн шинэчлэлийг энэ зун гэхэд дуусгах зорилт тавин ажиллаж байна, та бүхэн дэмжинэ гэдэгт итгэж байна гэв. Илтгэл нь хурлын материалд байгаа тул товчлов

Ё.Энхтөр : 2-р асуудлыг материалын дагуу Л.Цэвээнравдан хэлэлцүүлнэ.

Д.Цэвээнравдан: Компанийн санхүүгийн тайланд "Ая такс аудит"-ын компани аудит хийсэн. Тус аудитын компани нь орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ны-бо бүртгэлийн бодлого, тайлбар тодруулганд аудитын хяналт хийжээ. Компани нь санхүүгийн тайлангаар нийт 1676,7 сая ₮-ийн хөрөнгөтөй, үүнээс үндсэн хөрөнгө 30,5 сая ₮, дансны өглөг 1636,1 сая ₮, жилийн борлуулалтын орлого 144,4 сая ₮, зардал 121,4 сая ₮, ерөнхий ба удирдлагын зардал 22,7 сая ₮, татварын дараах ашиг 307,2 мянган төгрөгөөр аудитлагдсан байна. Мөнгөн гүйлгээний тайлангаар ажилчдын цалинд 69,1 сая ₮, татварт 3,7 сая ₮, НДШ-д 18,0 сая ₮, цахилгаанд 13,0 сая ₮ гм. гол гол зардлууд зохих ёсоор хянагдсан байна. Аудитын компанийн хувьд олон улсын стандартын дагуу бараа материал, өр авлага, татвар, тодруулгуудыг зохих журам, шаардлагад нийцсэн бүртгэгдэж ирсэн гэж дүгнэсэн байна. Аудитын дүгнэлт нь хурлын материалд бүрэн эхээрээ байгаа тул товчлов!

Ё.Энхтөр : Дараачийн асуудал бол ТУЗ-ийн сонгууль байгаа, компанийн ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны хурлаас 6 хүнийг ердийн, 3 хүнийг хараат бус гишүүдэд нэр дэвшихийг зөвшөөрч саналын хуудсанд оруулсан байна. Иймд та саналын хуудсаа одоо бөглөж тооллогын комисст өгөхийг хүсье. Мөн үндсэн илтгэлтэй холбоотой асуулт-хариултын цаг эхлэж байна, илтгэгч нараас сонирхсон зүйлээ асууж болно.

Б.Ганболд : ер нь ноосны үйлдвэрийн ирээдүй ямар байна вэ, зах зээл, өрсөлдөөн ихтэй байна уу?

Ц.Зоригт : Ер нь ирээдүйтэй үйлдвэрлэл гэж бид тооцдог. Ноосоо сайн бэлтгэвэл дотоодын хивсний үйлдвэр төдийгүй хөрш орнуудад ноосны хэрэгцээ багагүй байгаа нь мэдрэгддэг. Монголд байгаа томоохон ноос угаах үйлдвэрүүд голдуу хятад эзэн, хятад ажилчидтай, маш эрчимтэй ажиллаад урагш гаргаад байна. Ажилчдын хувьд орон нутгийн монгол ажилчид хариуцлага, сахилга, хөдөлмөрийн бүтээмжийн хувьд яагаад ч санасан хэмжээнд хүрэхгүй байна. Манай хувьд өндөр хүчин чадалтай технологийн шугамтай байх нь их ач холбогдолтойг ойлгож энэ жилээс шинэчлэл хийхээр төлөвлөж байгаа. Цагаан алт гээд ноосны хөтөлбөр байгаа боловч шинэ үйлдвэр, төслийн зээлтэй учраас бид энэ хөнгөлөлттэй зээл, хөтөлбөрт хамрагдаж чадахгүй байгаа гм. тайлбар ярилцлага болсон.

Ё.Энхтөр: Тооллогын комиссын шийдвэр гасан тул, санал шүүмжлэлээ үүгээр дуусгавар болгох уу ?

Бүгд зөвшөөрөв.

Тооллогын комиссын дарга Б.Соёлмаа санал хураалтын үр дүнгийн тухай тооллогын комиссын тогтоол №2, 3, 4-ыг уншин танилцуулж, тооллогын тооцоо, дүгнэлт материал, саналын хуудаснуудыг хавсаргасан тогтоолуудыг хурлын тэргүүлэгчид гардуулав.


Ё.Энхтөр: Санал хураалтын үр дүнгээр хурлаас гарах тогтоолын төслийг бүрэн дэмжсэн байна, "Компанийн үйл ажиллагааны үр дүнгийн тухай" 1-р тогтоол, "Компанийн санхүүгийн тайлангийн тухай" тогтоол №2., "ТУЗ-ийн ердийн гишүүдийг батлах тухай" 3-р тогтоол, "ТУЗ-ийн хараат бус гишүүдийг батлах тухай" 4-р тогтоолуудын төслүүдийг батлах уу ?

Бүгд дэмжин зөвшөөрч гар өргөв.

Ё.Энхтөр : Өнөөдрийн хурлын хэлэлцэх асуудал дуусч, төлөвлөсний дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын 4 тогтоол гарч асуудлуудаа шийдвэрлэлээ. Хурлын үр дүн, гарсан шийдвэрийн дагуу амжилттай сайн ажиллахыг компанийн удирдлагуудад хүсье, хуралд идэвхитэй оролцсон та бүхэнд талархал илэрхийлж энэ хурлаа хааж байна. .
Хурал 13. 15-д дуусав.

Хурлын тэмдэглэл хянасан :

Хурлын дарга:



Ё.Энхтөр

Хурлын тэмдэглэл хөтөлсөн :



Г.Амаржаргал